

**6-Р АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ
Б ХУВИЛБАР**

Хугацаа: 60 минут
20 оноо

Нийт

Сарьсан багваахай

Жигүүртэн, араатан хоёр хэрэлдэхэд сарьсан багваахай ямагт тэднээс хол зогсоно. Хэрэв жигүүртэн дийлвэл тэр жигүүртэн шувуудын сүрэгт нисэн ирж “Би угаасаа шувуу” гэдэг байжээ. Хэрэв араатан дийлвэл сарьсан багваахай араатны сүрэгт ирж “Би уулаасаа дөрвөн хөлтэй амьтан” гэдэг байжээ.

Гэтэл удалгүй араатан жигүүртэн хоёр найрамдахад бүгд түүнийг хөөжээ. Тэр цагаас хойш сарьсан багваахай ичээд өдөр нуугдаж, шөнө нисдэг болжээ.

Санаа муут яван хатна, сарьсан багваахай наранд хатна гэгчийн үлгэр энэ болой. Багваахай наранд хатдаг нь үнэн. Далавч нь үргэлж чийглэг байх шаардлагатай байдаг бөгөөд нар үзвэл хатсан навч шиг хунирчихна. Тийм учир шөнөөр гөрөөлдөг. Чөтгөр шулмын элч биш биз гэж бодогдмоор.

Ажиллах даалгавар:

1. Сарьсан багваахай юунаас болж хөөгдсөн бэ? /2 оноо/
 2. “Гэтэл удалгүй араатан сарьсан багваахайг хайр найргүй хөөжээ” гэсэн өгүүлбэрээс цөм бүтцийг ялгаад, тодорхойлоорой. /2 оноо/
 3. Эхийн гол санаанд тохирох хэлцийг сонгоорой. /1 оноо/
 - а. Сайн санааны үзүүрт тос
 - б. Улааныг үзэж урвах, шарыг үзэж шарвах
 - в. Өглөөний инээд үдшийн ханиад
 - г. Сохрын газар сохор, доголлонгийн газар доголлон..
 4. Сарьсан багваахайг араатан гэдгийг батлах баримт аль нь вэ? /1 оноо/
 - А. Араатнууд минь ээ, эвтэй байя гэдэг.
 - Б. Би угаасаа дөрвөн хөлтэй.
 - В. Би угаасаа шувуу.
 - Г. Жигүүртний сүрэгт ирж хов зөөдөг.
 5. “сахал+аа=? Залгаж бичээд, зөв бичих дүрмийг тайлбарлана уу. /2 оноо/
 6. Сарьсан багваахайг араатан гэдгийг батлах баримт аль нь вэ? /1 оноо/
 - А. Араатнууд минь ээ, эвтэй байя гэдэг.
 - Б. Би угаасаа дөрвөн хөлтэй.
 - В. Би угаасаа шувуу.
 - Г. Жигүүртний сүрэгт ирж хов зөөдөг.
 6. Зохиолын нэрийг зохиолын агуулгатай зөв харгалзуулна уу? /5 оноо/
 1. Л.Одончимэг “Хүүхдийн бор” өгүүллэг
 2. П.Хорлоо “Алт мөнгө хоёр” өгүүллэг
 3. Лакшмын соёрхол
 4. Кейко Тани “Цаасан онгоцны үлгэр” ахыгаа...
 5. Ч.Лодойдамба “Шаргачин” өгүүллэг
 - А. Өндөр уулсыг даван, өргөн далай
 - Б. Эрлэг Номун хааны, эд баялагийн тэнгэр..
 - В. Бүжигчин хүн харвал уран
 - Г. Унтахаар нөмөртэй газар олоод,
 - Д. Гэтэл манай нутагт нэгдэлжих хөдөлгөөний
- A. 1а,2д,3б,4в,5г. Б. 1д,2г,3б,4а,5в. В. 1в,2а,3б,4г,5д. Г. 1а,2д,3в,4б,5г.
7. Галигаас үндэсний бичигт хөрвүүлээрэй. /5 оноо/

Минү дэгүү Гэрэлм-а гэгүү-бэн сагаба. Алаг унаг-а бол ман-у адугун сүрүг-үн нигэ. Абу нидүн-ү дуран олул-а. Олан-у думба нэр-э-бэн боду.